



ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 06

Зуунмод

Иргэнд газар өмчлүүлэх талаар авах
зарим арга хэмжээний тухай

Аймгийн иргэдэд 2017 онд өмчлүүлэх газрын тухай аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, уг асуудалд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн Хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугар зүйлийн 18.1.2-ын “з”, 19 дүгээр зүйлийн 19.1, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийн 11.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийн 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, аймгийн иргэдэд 2017 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлын тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 2016 оны Гуравдугаар хуралдааны 05 дугаар тогтоолын дагуу иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Аймгийн иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Ж.Батжаргал/-д даалгасугай.

2.1 Тухайн сумын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршил, зориулалт, зураглалыг сумынх нь 2017 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах

2.2 Сумын газар өмчилж аваагүй иргэд, өмчлүүлэх газрын хэмжээ байршлын судалгааг шинэчлэн гаргаж, түүнд тулгуурлан төв суурин газрын тэг гортигыг тэлж шинэчлэх, зайлшгүй шаардлагатай бол өмнө тогтоосон нэг иргэнд өмчлүүлэх газрын хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлж өрчлөн тогтоох ажлыг зохион байгуулах

2.3 “Монгол улсын иргэнд газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх хуулийн хугацаа 2018 оны 5-р сард дуусахтай холбогдуулан газар үнэгүй өмчилж авахын ач холбогдол, газрын үнэ цэнэ, хуульд заасан хэмжээний газраа хугацаанд нь багтаан өмчилж авах талаархи ухуулга, сурталчилгааг өргөн хүрээтэй зохион байгуулж иргэн нэг бүрт хүргэх ажлын графикчилсан төлөвлөгөө гарган мөрдөж ажиллах, энэ ажлын талаар сум, багийн Засаг дарга, газрын даамал зэрэг холбогдох хүмүүсийн

ажлын хариуцлага, сахилгыг эрс өндөржүүлж ажиллах Сэргэлэн сумын нутагт шинээр өмчлүүлэхээр төлөвлөгдсөн газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийж, газар өмчлүүлэх ажилд Сэргэлэн, Зуунмод сумын Засаг дарга, газрын даамал, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох ажилтнуудыг татан оролцуулж хуулийн дагуу зохион байгуулах

2.4 Баянхангай, Баянцогт, Сэргэлэн, Цээл зэрэг сумдын зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа, иргэд сууришсан зарим тариалангийн талбайг хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ангилалаас хот суурин газрын ангилалд шилжүүлэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу боловсруулж, багийн иргэдийн Нийтийн болон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн зохих шийдвэрийг гаргуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн дөрөвдүгээр хуралдаанаар хэлэлцүүлэх

2.5 Газар өмчлөлийн явц удаашралтай байгаа Баян-Өнжүүл, Баянцагаан, Баянжаргалан, Бүрэн, Дэлгэрхаан, Өндөрширээт, Угтаалцайдам зэрэг сумдад анхаарал хандуулан тодорхой ажил зохион байгуулж газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх

2.6 Аймгийн Засаг даргаас Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сумын Засаг дарга нартай байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх болон үр дүнгийн гэрээнд газар өмчлөлийн ажлыг тодорхой тусгах, аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийн шалгуур үзүүлэлтэнд иргэнд газар өмчлүүлэх ажлын талаар тусган дүгнэж байх

2.7 Иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулахдаа сум, аймгийн харьяатай иргэдийн эрх ашгийг тэргүүн ээлжинд тавьж шийдвэрлэж байх

2.8 Аж ахуйн зориулалтаар аймаг, сумын төв, суурин газарт эзэмшиж байсан газраа давуу эрхээр үнээр нь өмчлөх саналыг хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газрын 2003 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал”-ын дагуу үнийг тогтоон өмчлүүлэх

3. Сумынхаа иргэдэд газар өмчлүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж, энэ ажлын талаар холбогдох хүмүүсийн мэдээллийг сонсож, зохих үүрэг даалгавар өгч, шаардлагатай арга хэмжээ авч, үр дүнд хүргэж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЭНХБАТ